

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ  
2020 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

Багануур дүүрэг

№	ҮНДЭСЛЭЛ	ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ
1.	БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл	Паркийн цахилгаан хангамжийн зураг төслийг гүйцэтгэгч “Мон-Энержи Консалт” ХХК нь ЭХЯ-наас 07 дугаар сарын 30-ны өдөр олгосон “БҮТП болон Төмрийн үйлдвэрийн эрчим хүчин нэгдсэн ерөнхий цахилгаан хангамж”-ын 51/2020/87 тоот дугаартай техникийн нөхцөл болон 09 дүгээр сарын 16-ны өдөр олгосон “Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах №2020/Ц-61 дугаартай даалгавар”-ын дагуу ЦДӨХАШ-ын урьдчилсан трассын шугамын зургийг боловсруулж, ЦДУС ТӨХК-тай зөвшилцэн зураг төсөлд нэмэлт өөрчлөлт оруулж байна.	100%
2.		7,3 км шугамыг барих ажлыг “МЕСЕС” ХХК нь геологийн судалгааны ажлаас эхлүүлсэн бөгөөд Ковид-19 цар тахалтай тэмцэх үндэсний хэмжээний үйл ажиллагааны улмаас түр зогсоосон байна.	-
3.		Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх тухай 11.03-ны 198, 11.05-ны 202 дугаартай албан бичгүүдийг нийслэлийн инноваци, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Д.Ихбаярт хүргүүлсэн.	100%
4.		БХБ-ын Сайд Б.Мөнхбаатар газрын дарга нарын хамт Багануур дүүрэгт 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр уулзалт зохион байгуулсан ба паркийн удирдлага Ч.Элбэгсайхан паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилт, тулгамдаж байгаа асуудлын талаар хэлэлцэж, БХБЯ дээр уулзалт зохион байгуулахаар тохиролцсон боловч цаг үеийн нөхцөл байдлын улмаас түр хойшлогдоод байна.	100%
5.		Багануур ХК-ийн удирдлага, ТҮЗ-ийн гишүүдтэй өнөөдрийг хүртэл хамтран ажиллах, мэдээлэл солилцох чиглэлээр 2 удаагийн уулзалтыг зохион байгуулан, 11 дүгээр сарын 05-ны өдөр шаардлагатай техникийн өгөгдэл мэдээллүүдийг хүлээн авч, шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг судлан ажиллаж байна.	100%
6.	Гүйцэтгэлийн зорилт 3.1.1	“Кластер ба инновацийн тухай ойлголт, хэрэгжүүлэх арга зам” сэдэвт зөвлөгөөний хөтөлбөрийг боловсруулж бэлтгэл ажлыг хангаад байсан боловч ковид-19 цар тахалын улмаас хойшлогдоод байна.	-
7.	Хамтын ажиллагаа	Паркийн үйл ажиллагаагаар холбогдох Барилга хот байгуулалтын яамтай хамтран ажиллах уулзалтыг Монгол улсад корона вирус дотооддоо бүртгэгдэн ЗГ-ын 178 дугаар тогтоолын дагуу тодорхойгүй хугацаагаар хойшлуулаад байна.	-

8.		МУИС-тай хамтран "Шар сүүг дахин боловсруулж шим тэжээлийн болон эмчилгээний зориулалттай бүтээгдэхүүн гаргах" инновацийн үйлдвэрийн төслийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Уулзалтыг цар тахалын улмаас тодорхойгүй хугацаагаар хойшлуулаад байна.	
9.	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж	Нийслэлийн нутгийн захирагааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажилласан ба "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-т 2020 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар хариутай 7, хариугүй 12 бичиг нийт 19 албан бичиг ирсэн ба шийдвэрлэлт 93.33 хувьтай байна. "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-аас ААНБ-уудад хариугүй 19 албан бичиг явуулсан ба шийдвэрлэлт 100 хувьтай байна. Мөн 10 дугаар сарын 30-ны өдөр 2 албан хаагчийн эзлжийн амралтыг ERP системд оруулан бүртгэсэн. 11 дүгээр сарын 17-ноос 12 дугаар сарын 01-ны өдөр хүртэл цахимаар ажиллах болсонтой холбогдуулан "UB ERP" системийн операторууд 11 дүгээр сарын 19-ний өдөр цахимаар ажиллах цагийн бүртгэлийн дэд системийг нээн албан хаагчид цагаа уг өдрөөс цахимаар бүртгүүлж эхэлсэн ба 17,18-ны өдрийн ажилчдын цаг бүртгэлийг системд цахимаар ажилласан төлвөөр нөхөн бүртгэсэн.	100%
10.	2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.2.1	baganuur-itp.mn цахим хуудасны хөгжүүлэлт, баяжилтыг тогтмол хийж, корона вирустэй холбоотой цаг үеийн мэдээг тасралтгүй хүргэж байна.	100%
11.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бусад үүрэгт ажлыг хугацаанд нь гүйцэтгэж ажилласан. Шилэн дансанд мэдээллийг агуулга, стандартын дагуу байршуулж байна.	100%
12.	Гүйцэтгэлийн зорилт 3.1.2	БҮТП-ийн 2021-2024 оны батлагдсан стратеги төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2019 оны 47 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу 2 дугаар бүлгийн загварт оруулан боловсруулж байна.	70%
13.	Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол, НЗД-ын 2020 оны А/35 дугаар захирамж	Багануур дүүргийн Гамшгаас хамгаалах бэлэн байдлын урьдчилсан үзлэгт 11 дүгээр сарын 10-ны өдөр штабын бүрэлдэхүүн хамрагдсан. 11 дүгээр сарын 12, 13-ны өдрийд Нийслэлээс зохион байгуулагдах байсан үзлэг ЗГ-ын 2020 оны "Бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 178 дугаар тогтоолыг үндэслэн тодорхойгүй хугацаагаар хойшлоод байна.	-
<b>НЭМЭЛТ АЖИЛ</b>			
14.	Нийслэлийн Засаг даргын А/108 дугаар захирамжийн биелэлтийг 7 хоног бүрийн пүрэв гарagt <a href="mailto:zendmaal@gmail.com">zendmaal@gmail.com</a> цахим хаягаар хүргүүлэн ажиллаж байна.	100%	
15.	Нийслэлийн Засаг даргын А/168 дугаар захирамжийн биелэлтийг 14 хоног бүрийн Баасан гарagt НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.	100%	
16.	УОК-ын 04 дүгээр албан даалгавар, НОК-ын 14 дүгээр хурлын тэмдэглэлээр үүрэг болгосон "Маскаа зүүе, гарaa угаая" 2 дугаар аяны хүрээнд зохион байгуулсан ажлын мэдээг 7 хоног бүрийн Лхагва гарagt Багануур дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн	100%	

	хэлтэст албан бичгээр, <a href="mailto:forza5737@gmail.com">forza5737@gmail.com</a> цахим хаягаар, нийслэлийн Эрүүл мэндийн газрын <a href="mailto:ubhealth2020@gmail.com">ubhealth2020@gmail.com</a> хаягт 7 хоног бурийн Пүрэв гарарт хүргүүлэн ажиллаж байна.	
17.	Нийслэл хотод Шинэ коронавирус “КОВИД-19” халдварт өвчин тархаж Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Нийслэлийн мэдээ нүүр номын хуудсанд байршуулсан мэдээллийг өдөр тутамдаа байгууллагын албан хаагчид өөрсдийн хувийн нүүр номын хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд түгзэсэн тухай мэдээг нэгтгэн НЭДТГ-ын холбогдох цахим хаягаар 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн тайлагнан ажиллаж байна.	100%
18.	НШУҮИГ-тай 2020 оны 04 дүгээр улиралд хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу албан хаагчийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр холбогдох бичиг баримтыг 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 200 дугаартай албан бичгээр НШУҮИГ-т хүргүүлсэн.	100%
19.	НЭДТГ-ын 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 03/6215, Багануур дүүргийн ЗДТГ-аас 11 дүгээр сарын 04-ний өдөр ирүүлсэн 04/78 дугаартай албан бичгийн дагуу 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан журам болон ERP системийн өргөдөл, гомдолын дэд системд оруулах өөрчлөлтийн санал байхгүй талаарх 203, 204 дугаартай албан бичгийг 11 дүгээр сарын 06-ны өдөр НЭДТГ, дүүргийн ЗДТГ-ын ТЗҮХ-т тус тус хүргүүлсэн.	100%
20.	Нийслэлийн 11 дүгээр сарын 02-ны өдрийн удирдах ажилтнуудын шуурхай хуралдааны үеэр өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг боловсруулан ERP системээр Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт, Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн, Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийн хэрэгжилт, үр дунд хийх хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн О.Мандах руу илгээсэн.	100%
21.	НЭДТГ-аас ирүүлсэн 2020 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 03/6321 дугаартай албан бичгийн дагуу Удирдлагын академийн мэргэжил дээшлүүлэх институттээс Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/-тэй хамтран зохион байгуулж буй “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага” болгино хугацааны сертификаттай сургалтад оролцуулах албан хаагчдын мэдээллийг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын мөн өдрийн 206 дугаартай албан бичгээр НЭДТГ-ын Хүний нөөцийн удирдлагын тасагт хүргүүлсэн.	100%
22.	НШУҮИГ-ын 11 дүгээр сарын 09-ний 02/438 дугаартай албан бичгийн дагуу Нийслэлийг хөгжүүлэх 2021-2025 оны үндсэн чиглэлд тусгуулах саналыг бэлтгэн байгууллагын 2021 оны төсвийн төслийн хамт 11 дүгээр сарын 10-ны өдрийн 207 дугаартай албан бичгээр НШУҮИГ-т, <a href="mailto:buyantogtokh.sidia@gmail.com">buyantogtokh.sidia@gmail.com</a> хаягаар цахимаар тус тус хүргүүлсэн.	100%
23.	Багануур дүүргийн ЗДТГ-ын 03/354 дугаартай албан бичгийн дагуу Багануур дүүргийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулах саналыг бэлтгэн 11 дүгээр сарын 10-ны 208 дугаартай албан бичгээр дүүргийн ТЗҮХ-т хүргүүлсэн.	100%
24.	НЭДТГ-ын 2020.11.10-ны өдрийн 10/6339 дугаартай албан бичгийн дагуу байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон түүний Тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан журмуудыг хэрэгжүүлэх явцад гарч байгаа хүндрэл бэрхшээлийн судалгааг гарган 2020.11.12-ны өдрийн 210 дугаартай албан бичгээр НЭДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн.	100%
25.	Төрөөс аж үйлдвэрийн талаар хэрэгжүүлэх бодлогын 2020 оны хэрэгжилтийн тайланг гаргаж байгаатай холбогдуулан холбогдох заалтуудын хүрээнд Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн 2020 оны биелэлтийг гарган НШУҮИГ-ын <a href="mailto:buyantogtokh.sidia@gmail.com">buyantogtokh.sidia@gmail.com</a> цахим хаягт 11 дүгээр сарын 18-ны өдөр илгээсэн.	100%

26.	Багануур дүүргийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн "Сурьеэгүй хамт олон аян зохион байгуулах тухай" А/326 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган ажилласан тухай тайланг дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэст 11 дүгээр сарын 20-ны өдрийн 213 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	100%
27.	Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг жилийн эцсийн байдлаар холбогдох фото тайлангийн хамт гарган НШУҮИГ-ын холбогдох мэргэжилтний цахим хаягт, НЗДТГ-т 11 дүгээр сарын 25-ны өдрийн 215 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.	100%
28.	Нийслэлийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг гарган 11 дүгээр сарын 30-ны өдөр НШУҮИГ-ын buyantogtokh@gmail.com хаягаар хүргүүлсэн.	100%
29.	НЗД-ын А/335 дугаар захирамжийн дагуу нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн жилийн эцсийн биелэлтийг гарган 11 дүгээр сарын 30-ны өдрийн 217 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн.	100%
30.	Багануур дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсээс ирүүлсэн 475 дугаартай албан бичгийн дагуу "Хөдөлмерийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах дүүргийн дэд хөтөлбөр"-ийн биелэлтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар боловсруулж байна.	90%

ХЯНАСАН:  
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:  
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ч. ЭЛБЭГСАЙХАН

Э. ЭНХЗАЯА